

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө



МОНЦАМЭ АГЕНТЛАГИЙН ДАРГА  
Б.ГАНЧИМЭГ ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.02.27 № 06.631  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу МОНЦАМЭ агентлагийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

МОНЦАМЭ агентлагийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар МОНЦАМЭ агентлагийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

МОНЦАМЭ агентлагийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Ганчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн ангилал, нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын иж бүрдлийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу МОНЦАМЭ агентлагийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

МОНЦАМЭ агентлагийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 30-наас 2020 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эс Жи Эм Ди -Аудит” ХХК-ийн аудитор М.Өсөхжаргал, Д.Жаргалсайхан, Б.Оюунцэцэг, Ч.Ням-Очир нар хариуцаж хэрэгжүүлэв.

МОНЦАМЭ агентлагийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

МОНЦАМЭ агентлаг нь улс оронд болон дэлхий дахинд болж буй үйл явдлын тухай мэдээ мэдээллийг цуглуулан шуурхай түгээх, Монгол Улсын түүх соёл, хөгжил дэвшлийг гадаадын олон нийтэд таниулан сурталчлах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Монгол Улсын төр, засгийн удирдлага ба төв байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, өргөн олон нийтийг улс орны дотоод амьдралын шуурхай мэдээллээр хангах,
- Гадаад ертөнц, олон хэмжээнд болж байгаа үйл явдлын мэдээллээр хангах,
- Монгол Улсын гадаад, дотоод бодлого, дотоодын үйл явдал, улс орны хөгжил дэвшлийг гадаадад мэдээлэх, сурталчлан таниулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (Шинэчилсэн найруулга );
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль;
- ХХОАТ-ын тухай хууль (Шинэчилсэн найруулга );

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус МОНЦАМЭ агентлагийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

МОНЦАМЭ агентлаг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Венеца” программ хангамжийг ашигладаг байна.

МОНЦАМЭ агентлагийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар МОНЦАМЭ агентлагийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,527,363.5 мянган төгрөгөөс тооцон 30,547.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангаас 36,687.6 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүн өмнөх оноос 120.1 хувиар нэмэгдсэнтэй холбоотой болно.

## 2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

МОНЦАМЭ агентлагийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47,741.3 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	35,026.4	68,719.7	33,693.3
Урьдчилгаа	-	30,000.0	30,000.0
Бараа материал	39,383.9	42,188.7	2,804.8
Үндсэн хөрөнгө	671,841.2	653,084.4	(18,756.8)
<b>Нийт хөрөнгө</b>	746,251.5	793,992.8	47,741.3
Өр төлбөр	725.0	509.4	(215.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	745,526.5	793,483.4	47,956.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	746,251.5	793,992.8	47,741.3

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 68,719.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь татварын суутгалын зөрүүтэй холбоотой ажиллагсдаас авлага 198.0 мянга, байгууллагаас авах авлага 48,261.4 мянга, төлбөртэй үйлчилгээний 20,260.3 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь тайлант онд гэрээгээр гүйцэтгэх ажлын гүйцэтгэлээс шалтгаалж нэмэгдсэн нь байна.

Урьдчилгаа данс 30,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь Засгийн газрын нөөц сангаас тендерийн урьдчилгаанд зарцуулсан хөрөнгөтэй холбоотой байна.

2019 оны жилийн эцэст ХХОАТ-ын суутгалын зөрүүнээс 509.4 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой өр төлбөр үүссэн байна.

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 төсөл хөтөлбөрт зориулж 1,640,432.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,455,432.6 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс, үйл ажиллагааны орлогоос 213,938.2 мянга, нийт 1,669,370.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 1,639,784.8 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 29,586.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,639,784.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 298.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 21.7 мянган төгрөг, хангамжийн материалын зардлаас 10.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 21.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас 292.7 мянган төгрөгийг тус тус тайлант хугацаанд зарцуулалгүй улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Засгийн газрын нөөц хөрөнгөөс, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 143,705.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 30,000.0 мянган төгрөг нийт 173,750.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардалд 30,000.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 143,705.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 19,976.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7,505.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,943.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 8,527.98 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Тус агентлаг нь улсын мэдээний маягт хэвлэх ажил, үйлчилгээнд тендер зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.6-д “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно”, 8.7.1-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэж заасантай тус тус нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөх.

2. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн өртөгтэй, 2019 оны жилийн эцсийн байдлаар 8 нэр төрлийн 5,480.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн, мөн агентлагийн даргын 2019-04-18-ны өдрийн Б/61 тоот тушаалаар 2,025.0 мянган төгрөгийн урамшуулал илүү олгогдсон байна.

Шийдвэрлэсэн нь: Нийт 7,505.0 мянган төгрөгийн гүйлгээг санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар илэрсэн 8,527.8.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

МОНЦАМЭ агентлагт санхүүжилтээр орж ирсэн хөрөнгийн зарцуулалтын тушаал шийдвэр нь холбогдох хуулиудад нийцсэн эсэх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилсэн эсэх, анхан шатны болон И-баримтын бүрдлийг дараагийн аудитаар анхаарч авч үзэхээр шийдвэрлэв.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

МОНЦАМЭ агентлаг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд цаг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.



### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,625.6 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлжээ.

Нийт 81,396.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид МОНЦАМЭ агентлагийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

МОНЦАМЭ агентлагийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### *1. Балансын данстай холбоотой асуудал*

##### 1.1. Илрүүлэлт:

2019 оны 12 сарын 3-ны Б/213 тоот тушаалаар ажилчдад олгосон 18,000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосноос ХХОАТ суутгаагүй байгаа нь ХХОАТ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйл "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 11 дүгээр зүйлийн 1.2 "ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого", ХХОАТ-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:", 16 дугаар зүйлийн 16.1.1-д "Хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж;" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

##### 1.2 Эрсдэл:

Татварын эрсдэл үүсэх, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11.1.2 дахь заалт зөрчигдөх,

##### 1.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11.1.2-т "Ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;" гэсэн заалтыг мөрдөж ажиллах,

##### 1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

#### *2. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал*

##### 2.1 Илрүүлэлт:

Зардлыг төсвийн зардлын эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй байгаа нь хууль, журмын заалтуудыг зөрчиж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар

зүйлийн 6.7 “төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах”, Сангийн сайдын 2015.01.20-ны өдрийн 7 тоот тушаалыг зөрчиж байна.

## 2.2 Эрсдэл:

Төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээлэл буруу илэрхийлэгдэх, төсвийн зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөөгүй байх;

## 2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарлагын ангиллыг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах,

## 2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сангийн сайдын 2015.01.20-ны өдрийн 7 тоот тушаал, Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 55 тоот тушаалын “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын 6 дугаар хавсралтыг мөрдөж ажилласан болно.

## 3. Хөрөнгөд бүртгэлээр тавих хяналттай холбоотой асуудал:

### 3.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

### 3.2 Эрсдэл:

Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт сулрах, анхан шатны баримтыг бүрдэлгүй ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан байх;

### 3.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын үнэн зөв, цаг тухайд нь бүрдүүлж байх, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллах,

### 3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.6, 13.7 заалтууд болон өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>74,410,394.77</b>	<b>140,908,384.30</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	35,026,413.03	68,719,668.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	196,666.72	197,999.54
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	34,301,326.00	20,260,300.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	528,420.31	48,261,369.26
3351	Байгууллагаас авах авлага	528,420.31	48,261,369.26
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	30,000,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	30,000,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		30,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	39,383,981.74	42,188,715.50
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,194,661.87	6,065,337.25
35110	Тусгай зориулалттай материал	7,194,661.87	6,065,337.25
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	32,189,319.87	36,123,378.25
35410	Бичиг хэргийн материал	18,279,015.00	22,891,930.25
35420	Аж ахуйн материал	6,659,875.00	7,113,077.00
35430	Сэлбэг хэрэгсэл	67,000.00	
35440	Түлш, шатах тослох материал	1,071,818.87	954,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,111,611.00	5,164,371.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>671,841,210.47</b>	<b>653,084,433.69</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	671,841,210.47	653,084,433.69
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	578,861,550.51	580,656,984.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	274,077,529.00	274,077,529.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		29,532,907.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,955,000.00	66,955,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	62,205,000.18	66,955,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,055,182,248.30	1,151,748,781.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	782,730,903.56	850,508,726.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,759,967.93	64,759,967.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	30,969,330.98	35,339,204.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,745,440.00	3,745,440.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		340,494.60
39217	Ном	2,046,600.00	2,046,600.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	92,979,659.96	72,427,448.84
39301	Програм хангамж	99,160,000.00	99,623,084.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	20,978,000.04	41,993,295.16
39303	Бусад биет бус хөрөнгө	14,797,660.00	14,797,660.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>746,251,605.24</b>	<b>793,992,817.99</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>725,087.03</b>	<b>509,368.80</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	725,087.03	509,368.80
<b>413</b>	<b>Өглөг</b>	725,087.03	509,368.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	725,087.03	509,368.80
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>745,526,518.21</b>	<b>793,483,449.19</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	745,526,518.21	793,483,449.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	923,780,524.52	923,780,524.52
51101	Өмч: - төрийн	923,780,524.52	923,780,524.52
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(456,076,975.31)	(408,120,044.33)
51210	Өмнөх үеийн үр дүн	(705,653,025.71)	(455,343,101.54)
51220	Тайлант үеийн үр дүн	249,576,050.40	47,223,057.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	277,822,969.00	277,822,969.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>746,251,605.24</b>	<b>793,992,817.99</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,776,939,576.08</b>	<b>1,881,605,789.58</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>225,153,788.08</b>	<b>204,518,189.58</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	213,365,788.08	202,759,189.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	213,365,788.08	202,759,189.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	192,612,892.08	185,233,044.86
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,752,896.00	14,490,528.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		3,035,616.72
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	11,788,000.00	1,759,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	11,788,000.00	1,759,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,551,785,788.00</b>	<b>1,677,087,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,531,785,788.00	1,455,432,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,234,535,300.00	1,455,432,600.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	297,250,488.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,000,000.00	221,655,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		191,655,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,000,000.00	30,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,527,363,525.68</b>	<b>1,834,382,732.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,527,363,525.68</b>	<b>1,834,382,732.37</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,500,034,780.63	1,714,603,581.68
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	996,822,428.25	1,133,961,781.95
210101	Үндсэн цалин	996,822,428.25	1,133,961,781.95
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	122,156,930.60	145,108,626.80
210201	Тэтгэврийн даатгал	81,429,810.00	98,673,866.22
210202	Тэтгэмжийн даатгал	10,175,672.30	11,608,690.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,147,867.30	9,286,952.11
210204	Ажилгүйдлийн даатгал	2,040,021.00	2,321,738.03
210205	Эрүүл мэндийн даатгал	20,363,560.00	23,217,380.29
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,407,500.00	36,385,734.61
210301	Гэрэл, цахилгаан	15,027,847.95	14,549,286.25
210302	Түлш, халаалт	13,028,168.91	16,845,228.66
210303	Цэвэр, бохир ус	8,351,483.14	4,991,219.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	54,618,801.21	51,706,633.93
210401	Бичиг хэрэг	3,720,150.00	1,405,470.00
210402	Тээвэр, шатахуун	7,233,181.13	7,437,818.87
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	34,499,838.08	33,751,645.06
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,440,000.00	1,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,725,632.00	7,671,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	132,600.00	132,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	132,600.00	132,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,885,390.00	6,524,237.00
210604	Урсгал засвар	8,885,390.00	6,524,237.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	15,614,700.00	27,943,010.00
210701	Гадаад албан томилолт	10,917,203.00	9,927,197.00
210702	Дотоод албан томилолт		298,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,697,497.00	17,717,813.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	158,823,655.83	171,622,222.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,437,450.00	61,828,837.02

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	700,210.00	705,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	283,774.00	278,774.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	842,000.00	640,000.00
210807	Газрын төлбөр	230,296.00	230,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	94,329,925.83	105,938,411.87
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>106,572,774.74</b>	<b>141,218,734.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,581,036.00	13,432,341.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,991,738.74	127,786,393.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,328,745.05</b>	<b>119,779,150.69</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,905,000.00</b>	<b>90,193,100.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		2,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		70,193,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,905,000.00	18,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,423,745.05</b>	<b>29,586,050.69</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,423,745.05	29,586,050.69
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>249,576,050.40</b>	<b>47,223,057.21</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>249,576,050.40</b>	<b>47,223,057.21</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,747,205,173.46</b>	<b>1,843,075,818.03</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>195,419,385.46</b>	<b>213,938,218.03</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	195,419,385.46	213,938,218.03
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	195,419,385.46	213,938,218.03
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	195,419,385.46	213,938,218.03
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,551,785,788.00</b>	<b>1,629,137,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,531,785,788.00	1,455,432,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,234,535,300.00	1,455,432,600.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	297,250,488.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,000,000.00	173,705,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		143,705,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,000,000.00	30,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,449,954,685.46</b>	<b>1,720,840,818.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,449,954,685.46</b>	<b>1,720,840,818.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,422,625,940.41</b>	<b>1,601,061,667.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	998,348,882.43	1,136,420,254.15
210101	Үндсэн цалин	998,348,882.43	1,136,420,254.15
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	119,979,200.00	142,089,900.00
210201	Тэтгэврийн даатгал	79,978,135.00	96,621,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,994,267.00	11,367,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,002,613.00	9,093,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,003,652.00	2,273,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,000,533.00	22,734,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,407,500.00	36,385,734.61
210301	Гэрэл, цахилгаан	15,027,847.95	14,549,286.25
210302	Түлш, халаалт	13,028,168.91	16,845,228.66
210303	Цэвэр, бохир ус	8,351,483.14	4,991,219.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	69,023,423.08	64,723,081.06
210401	Бичиг хэрэг	17,994,114.00	15,063,293.00
210402	Тээвэр, шатахуун	7,040,000.00	6,520,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	34,499,838.08	33,751,645.06
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,440,000.00	1,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,049,471.00	7,948,143.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	132,600.00	132,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	132,600.00	132,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,195,640.00	22,197,787.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00	12,000,000.00
210604	Урсгал засвар	10,195,640.00	10,197,787.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	16,119,700.00	29,289,700.00
210701	Гадаад албан томилот	10,917,203.00	9,927,197.00
210702	Дотоод албан томилот	205,000.00	298,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,997,497.00	19,064,503.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	150,575,458.90	155,994,928.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,437,450.00	61,828,837.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	700,210.00	705,900.00



210804	Тээврийн хэрэгслийн татвар	283,774.00	278,774.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,995,000.00	1,992,000.00
210807	Газрын төлбөр	230,296.00	230,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	84,928,728.90	88,959,117.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,843,536.00</b>	<b>13,827,682.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,843,536.00	13,827,682.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,328,745.05</b>	<b>119,779,150.69</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,905,000.00</b>	<b>90,193,100.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,905,000.00	2,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		70,193,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		18,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,423,745.05</b>	<b>29,586,050.69</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,423,745.05	29,586,050.69
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>297,250,488.00</b>	<b>122,235,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>297,250,488.00</b>	<b>122,235,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>297,250,488.00</b>	<b>122,235,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>297,250,488.00</b>	<b>122,235,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	297,250,488.00	122,235,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(297,250,488.00)</b>	<b>(122,235,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>



#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	908,982,864.52	70,091,215.16	(718,705,197.78)	260,368,881.90
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	908,982,864.52	70,091,215.16	(718,705,197.78)	260,368,881.90
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	14,797,660.00	207,731,753.84	13,052,172.07	235,581,585.91
Тайлант үеийн үр дүн	-	-	249,576,050.40	249,576,050.40
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	923,780,524.52	277,822,969.00	(456,076,975.31)	745,526,518.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	733,873.77	733,873.77
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	923,780,524.52	277,822,969.00	(455,343,101.54)	746,260,391.98
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	47,223,057.21	47,223,057.21
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	923,780,524.52	277,822,969.00	(408,120,044.33)	793,483,449.19

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/төгрөг/			
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,640,432,600.00	1,639,784,767.34	647,832.66	99.9
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,640,432,600.00	1,639,784,767.34	647,832.66	99.9
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,568,239,500.00	1,567,591,667.34	647,832.66	99.9
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,136,719,100.00	1,136,420,254.15	298,845.85	99.9
Үндсэн цалин	927,377,400.00	1,136,420,254.15	(209,042,854.15)	122.5
Нэмэгдэл	15,236,200.00	-	15,236,200.00	-
Унаа хоолны хөнгөлөлт	194,105,500.00	-	194,105,500.00	-
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	142,089,900.00	142,089,900.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	96,621,200.00	96,621,200.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	11,367,200.00	11,367,200.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	9,093,800.00	9,093,800.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	2,273,400.00	2,273,400.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	22,734,300.00	22,734,300.00	-	100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,407,500.00	36,385,734.61	21,765.39	99.9
Гэрэл, цахилгаан	14,206,000.00	14,549,286.25	(343,286.25)	102.4
Түлш, халаалт	11,115,000.00	16,845,228.66	(5,730,228.66)	151.5
Цэвэр, бохир ус	11,086,500.00	4,991,219.70	6,095,280.30	45.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	64,733,700.00	64,723,081.06	10,618.94	99.9
Бичиг хэрэг	11,782,100.00	15,063,293.00	(3,281,193.00)	127.8
Тээвэр, шатахуун	5,040,000.00	6,520,000.00	(1,480,000.00)	129.4
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	42,942,200.00	33,751,645.06	9,190,554.94	78.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,440,000.00	1,440,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,529,400.00	7,948,143.00	(4,418,743.00)	225.2
<b>Нормативт зардал</b>	132,600.00	132,600.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	132,600.00	132,600.00	-	100.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,200,000.00	10,197,787.00	2,213.00	99.9
Урсгал засвар	10,200,000.00	10,197,787.00	2,213.00	99.9
<b>Томилолт, зочны зардал</b>	7,819,700.00	7,819,700.00	-	100.0
Гадаад албан томилолт		5,700,197.00	(5,700,197.00)	#DIV/0!
Дотоод албан томилолт	819,700.00	298,000.00	521,700.00	36.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	7,000,000.00	1,821,503.00	5,178,497.00	26.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	156,287,600.00	155,994,928.52	292,671.48	99.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,835,200.00	61,828,837.02	6,362.98	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	705,900.00	705,900.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	278,774.00	21,226.00	92.9

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	1,992,000.00	8,000.00	99.6
Газрын төлбөр	230,300.00	230,300.00	-	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	89,216,200.00	88,959,117.50	257,082.50	99.7
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,849,400.00</b>	<b>13,827,682.00</b>	<b>21,718.00</b>	<b>99.8</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	13,849,400.00	13,827,682.00	21,718.00	99.8
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>72,193,100.00</b>	<b>72,193,100.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>72,193,100.00</b>	<b>72,193,100.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	70,193,100.00	70,193,100.00	-	100.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,640,432,600.00</b>	<b>1,639,784,767.34</b>	<b>647,832.66</b>	<b>99.9</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,455,432,600.00</b>	<b>1,425,846,549.31</b>	<b>29,586,050.69</b>	<b>99.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	1,455,432,600.00	1,425,846,549.31	29,586,050.69	99.9
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>185,000,000.00</b>	<b>213,938,218.03</b>	<b>(28,928,218.03)</b>	<b>115.6</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	180,000,000.00	213,938,218.03	(33,928,218.03)	118.8
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00		5,000,000.00	-
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>108</b>	<b>108</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Удирдах ажилтан	2	2	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	99	99	-	100.0
Үйлчлэх ажилтан	7	7	-	100.0
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>108</b>	<b>108</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15	15	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	93	93	-	100.0

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөг/
	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>173,705,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>30,000,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	12,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	12,000,000.00
21060 1	Багаж, техник, хэрэгсэл	-	12,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	18,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	18,000,000.00
21320 9	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	18,000,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>143,705,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	143,705,000.00
22200 1	Тоног төхөөрөмж	-	113,705,000.00
22300 1	Бусад хөрөнгө	-	30,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>173,705,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>173,705,000.00</b>
13110 3	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	143,705,000.00
13110 5	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	30,000,000.00

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	МОНЦАМЭ агентлагийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019			САГ-2020/19/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	МОНЦАМЭ агентлагийн		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Улсын мэдээний маягт хэвлэх ажил, үйлчилгээнд тендер зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна.	-	Албан шаардлага	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
2	2019 оны 12 сарын 3-ны Б/213 тоот тушаалаар 2 ажилтны нийгмийн асуудал шийдвэрлэхэд 18,000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосноос ХХОАТ суутгаагүй байна.	1,800.0	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
3	Төсвийн зарлагын ангиллыг зөв бүртгээгүй.Тухайлбал; Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлын бүрэлдэхүүнд дараах зардлуудыг тусгажээ. Үүнд: Хүлээн авалтын арга хэмжээний зардал 827.3 мянган төгрөг, цэвэрлэгээний материалын 1,191.1 мянган төгрөг, ариун цэврийн цаас 1,925.0 мянган төгрөг байна.	3,943.4	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
4	Тайлант хугацаанд анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайланд тусгасан байна.	5,612.7	Зөвлөмж	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Ганчимэг С.Золзаяа
5	Нийт дүн	11,356.1			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 05 № 02/84  
С.Т.Т. 20 20/19/С.ГА - 023

Улаанбаатар хот

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цагалбарт хугацаанд хийсэн “МОНЦАМЭ агентлаг”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус агентлаг нь улсын мэдээний маягт хэвлэх ажил, үйлчилгээнд тендер зарлаагүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.6-д “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно”, 8.7.1-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-т “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4,8.6,8.7.1 дэх заалтуудыг мөрдөн ажиллах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “МОНЦАМЭ агентлаг”-ийн дарга Б.Ганчимэг, ерөнхий нягтлан бодогч С.Золзаяа нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц.НАРАНЧИМЭГ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  
Д.ЭХБАЯР

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ДАРГА  
Б.ГАНЧИМЭГ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
С.ЗОЛЗАЯА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

001080331



